



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**ӨДРИЙН ХӨТӨЛБӨР**  
**САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ТЭНХИМ**

**Боржигон**  
**Энхболд СҮРЭНЦЭЦЭГ**

**ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ АШИГТ АЖИЛЛАГААНД**  
**НӨЛӨӨЛӨХ НЬ/АРИЛЖААНЫ БАНКНЫ ЖИШЭЭН**  
**ДЭЭР/**



Мэргэжлийн индекс  
041203

Бизнесийн удирдлагын бакалаврын  
зэрэг горилсон  
**Дипломын төсөл**

Удирдсан  
Э.Тамир /Мастер/

Улаанбаатар. 2023



**САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
**САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН ТЭНХИМ**



**Боржигон**  
**Энхболд СҮРЭНЦЭЦЭГ**

**ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ АШИГТ АЖИЛЛАГААНД**  
**НӨЛӨӨЛӨХ НЬ/АРИЛЖААНЫ БАНКНЫ ЖИШЭЭН**  
**ДЭЭР/**



Мэргэжлийн индекс  
041203

**Бизнесийн Удирдлагын Бакалаврын Зэрэг**  
**Горилсон Дипломын Төсөл**

Удирдагч: ..... Э.Тамир /МВА/

Улаанбаатар. 2023

## ГАРЧГИЙН ТОВЬЁОГ

|  |     |
|--|-----|
| ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....  | i   |
| ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ .....   | ii  |
| ТОВЧ ХУРААНГУЙ.....  | iii |
| ОРШИЛ .....  | 1   |
| I БҮЛЭГ. Онолын судалгаа .....   | 2   |
| 1.1 Сэдвийн судлагдсан байдал .....  | 2   |
| 1.2 Дижитал шилжилт.....   | 3   |
| 1.3 Хууль эрх зүй болон төрийн зохицуулалт .....                           | 10  |
| 1.4 Цахим банкны Монгол дахь өнөөгийн нөхцөл байдал.....                   | 11  |
| II БҮЛЭГ. ӨНӨӨГИЙН САЛБАРЫН СУДАЛГАА .....                                 | 14  |
| 2.1 Голомт банкны товч танилцуулга.....                                    | 14  |
| 2.2 Банкуудын дижитал бүтээгдэхүүний танилцуулга ба харьцуулалт.....       | 17  |
| 2.3 Голомт банк- Сошиал Пэй дпижитал хэтэвчийн инновац .....               | 18  |
| 2.4 Олон улсын дижитал шилжилтийн чиг хандлага .....                       | 23  |
| III БҮЛЭГ. ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ .....  | 24  |
| 3.1 ҮНДСЭН ХЭСЭГ .....   | 24  |
| 3.2 Активийн өгөөжийн шинжилгээ.....                                       | 26  |
| 3.3 Ашигт ажиллагааны шинжилгээ.....                                       | 27  |
| 3.4 Голомт банкны ашигт ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлийн шинжилгээ....  | 30  |
| 3.5 Олон улсын активын өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт..... | 31  |
| 3.6 Голомт банкны ковидын үеийн нөхцөл байдал ба санхүүгийн үзүүлэлтүүд... | 32  |
| ДҮГНЭЛТ .....  | 37  |
| НОМ ЗҮЙ.....   | iv  |

## **ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ**

|   |    |
|---|----|
| Хүснэгт 1.1 Дотоодод хийгдсэн судалгааны ажлууд.....                          | 2  |
| Хүснэгт 1.2 Банкны салбар дахь технологийн хөгжлийн нөлөөлөл .....            | 6  |
| Хүснэгт 2.1 Голомт банкны дижитал нэвтрэлт .....                              | 15 |
| Хүснэгт 2.2 Дижитал бүтээгдэхүүний танилцуулга ба харьцуулалт .....           | 17 |
| Хүснэгт 3.1 Голомт банкны активын өгөөжийн шинжилгээ .....                    | 26 |
| Хүснэгт 3.2 Голомт банкны ашигт ажиллагааны шинжилгээ .....                   | 28 |
| Хүснэгт 3.3 Голомт банкны ашигт ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлийн шинжилгээ | 30 |
| Хүснэгт 3.4 Голомт банкны 5 жилийн санхүүгийн үр дүн(сая төгрөгөөр) .....     | 35 |

## ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

|  |    |
|--|----|
| Зураг 1.1 Аж үйлдвэрийн 4-р хувьсгал .....                                       | 3  |
| Зураг 1.2 Ашигт ажиллагаа ба санхүүгийн ашигт ажиллагаа хоорондын хамаарал ..... | 5  |
| Зураг 1.3 Банк санхүүгийн салбарт бий болсон инновациуд.....                     | 6  |
| Зураг 1.4 Монгол Улсын интернэт хэрэглэгчдийн тоо.....                           | 9  |
| Зураг 1.5 Интернэт хэрэглэгчдийн тоо.....  | 11 |
| Зураг 1.6 Хэрэглэгчдийн эзлэх хувь.....  | 12 |
| Зураг 1.7 Нийт гүйлгээний тоонд эзлэх хувь.....                                  | 12 |
| Зураг 1.8 Монголын арилжааны банкуудын нийт активын үзүүлэлт.....                | 13 |
| Зураг 2.1 Дижитал шилжилтийн 2018 оны тайлан .....                               | 19 |
| Зураг 2.2 Дижитал шилжилтийн 2019 оны тайлан .....                               | 20 |
| Зураг 2.3 Дижитал шилжилтийн 2020 оны тайлан .....                               | 21 |
| Зураг 2.4 Дижитал шилжилтийн 2021 оны тайлан .....                               | 21 |
| Зураг 2.5 SocialPay дижитал хэтэвчийн функцууд .....                             | 22 |
| Зураг 2.6 Арилжааны банкуудын дижитал хандлага.....                              | 23 |
| Зураг 3.1 Цэвэр ашиг (тэрбум төгрөг).....  | 24 |
| Зураг 3.2. Үйл ажиллагааны ашиг (тэрбум төгрөг).....                             | 25 |
| Зураг 3.3. Свопын нөлөө (тэрбум төгрөг).....                                     | 26 |
| Зураг 3.4. Сан, үнэлгээний зардал (тэрбум төгрөг).....                           | 26 |
| Зураг 3.5 Голомт банкны орлого болон ашгийн хэмжээ /сая.төг/ .....               | 29 |
| Зураг 3.6. Голомт банкны ROE харьцаа /K <sub>1</sub> /.....                      | 30 |
| Зураг 3.7. Голомт банкны ROA харьцаа /K <sub>2</sub> / .....                     | 31 |
| Зураг 3.8 Олон улсын активын өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт .... | 31 |
| Зураг 3.9. Нийт актив (тэрбум төгрөг) .....                                      | 33 |
| Зураг 3.10. Харилцах хадгаламж (тэрбум төгрөг).....                              | 33 |
| Зураг 3.11. Цэвэр зээл (тэрбум төгрөг) .....                                     | 34 |
| Зураг 3.12. Өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг).....                                  | 34 |
| Зураг 3.13. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар .....                                 | 35 |

## **ТОВЧ ХУРААНГУЙ**

Энэхүү судалгааны ажлын зорилго нь арилжааны банкны цахим шилжилттэй холбоотой банкны үр ашиг, ашигт ажиллагаанд хэрхэн нөлөөлсөн, Голомт банкны Сошиал Пэй бүтээгдэхүүн үйлчилгээний орлого зардал нь санхүүгийн тайланд нөлөөлдөг хэсэгт ашигт ажиллагаа, тэдгээрт нөлөөлөгч хүчин зүйлүүдийг судалж, ашигт ажиллагааны түвшинг үнэлж улмаар дээшлүүлэх боломжийг тодорхойлох юм.

Судалгааны ажлын хүрээнд том Банкны нэг болох Голомт банк дээр судлагаа хийв. Дижитал шилжилтийг идэвхтэй хэрэгжүүлж байгаа салбар болох банкны салбарт дижитал шилжилт ямар түвшинд, хэрхэн явагдаж тэр нь байгууллагад ямар нөлөө үзүүлж байгааг судлахыг зорив.

**Түлхүүр үгс:** Дижитал шилжилт, үр ашиг, арилжааны банк, онлайн банк, ашигт ажиллагаа

# ДИГИТАЛ ШИЛЖИЛТ АШИГТ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛӨХ НЬ/АРИЛЖААНЫ БАНКНЫ ЖИШЭЭН ДЭЭР/

## ОРШИЛ

### Сэдэв сонгосон үндэслэл

Дижитал шилжилт нь байгууллагын үйл ажиллагаа, үйлчлүүлэгчдэд үнэ цэнийг хүргэх арга хэлбэрийг өөрчилж, бизнесийн талбарт төрөл бүрийн технологиудыг нэгтгэх үйл явц юм. Уламжлалт хэрэглэгч-бизнесийн харилцаа дижиталчлалаар өөрчлөгдөж байна. Энэ нь мөн байгууллагыг сорьж, шинийг санаачилж, тодорхойгүй байдлыг даван туулахад хүргэдэг нэг төрлийн соёлын өөрчлөлт юм. Энэхүү дижитал эрин үед жижиг аж ахуйн нэгжүүдээс эхлээд том корпорациудад хөгжих зайлшгүй шаардлагатай. Ингэснээр эцсийн хэрэглэгч туршлагажиж, бизнесийн үйл явцын өөрчлөлт, өгөгдлийг илүү хүлээцтэй байх болно. COVID-19 тахлын үед зах зээл дэх байр сууриа хадгалж үлдэхийн тулд хүчин чармайлт гаргаж байна. Банкны салбар нь бусад бизнесийн нэгэн адил шинэ үйл явцыг нэвтрүүлэх, дижитал технологиудыг өдөр тутмын үйл ажиллагаандаа оруулахыг хичээдэг. Олон улсын түвшинд дижитал шилжилттэй холбоотой олон судалгааны ажлууд хийгдэж байгаа дотор дижитал шилжилтийн байгууллага дахь нөлөөллийг судлах ажлууд нилээд хувийг эзэлж байна. Тиймээс дижитал шилжилтийг идэвхтэй хэрэгжүүлж байгаа салбар болох банкны салбарт энэ нь ямар түвшинд, хэрхэн явагдаж байгааг судлахыг зорив.

### Судалгааны ажлын зорилго, зорилтууд:

Судалгааны ажилд дэвшүүлсэн зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

- Голомт банкны ашигт ажиллагааны өнөөгийн байдлыг судлах
- Дю-понтын аргаар ашигт ажиллагааны шинжилгээг хийх
- Ялгаврын тооцооны аргаар хүчин зүйлийн шинжилгээг хийх
- Жилийн тайлангуудад санхүүгийн шинжилгээ хийн, өөрчлөлтийг харьцуулах

### Судалгааны ажлын арга зүй

Сүүлийн таван жилийн хугацаанд Монгол Улсын ихэнх банкууд дотоод үйл явц, үйлчлүүлэгчдэд чиглэсэн бүтээгдэхүүнүүддээ дижитал шилжилт нэвтрүүлж, хэрэгжүүлсэн. Дижитал шилжилт нь банкны салбарын орлого, үйл ажиллагааны зардал, ашигт байдалд хэрхэн нөлөөлж байгааг олж мэдэхийн тулд холбогдох бүх санхүүгийн мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн

## I БҮЛЭГ. ОНОЛЫН СУДАЛГАА

### 1.1 Сэдвийн судлагдсан байдал

Судлагдсан байдлын судалгааг гүйцэтгэхдээ СЭЗИС-ийн бакалаврын болон мастерын зэрэг горилсон, мөн гадаадын докторын зэрэг горилсон судлаачдын бүтээлүүдтэй танилцаж, өөрийн судалгааны ажлын сэдвийг дэлгэрүүлэн судалсан болно.

#### Хүснэгт 1.1 Дотоодод хийгдсэн судалгааны ажлууд

| № | Судлаач ба судалгааны нэр   | Судалсан он | Судалгааны агуулга   |
|---|---|-------------|--|
| 1 | З. Ундрал “Арилжааны банкнуудын дижитал шилжилтийн бэлэн байдлыг үнэлэх нь  | 2020 он     | Дижитал банкны шилжилтийн үе шат, бизнес загварыг тодорхойлон одоогийн Монгол улсын арилжааны банкнуудын дижитал шилжилтийг судалгааны загварчлалаар үнэлж өнөөгийн нөхцөл байдалд дүгнэлт гарган олон улсын түвшинтэй харьцуулсан   |
| 2 | Ц. Анхзүсэм “Арилжааны банкны цахим үйлчилгээнд ТТҮҮБ-ын оролцоог нэвтрүүлэх нь   | 2017 он     | Монгол арилжааны банкууд цахим үйлчилгээг нэвтрүүлэх, хөгжүүлэхдээ уламжлалт чиг хандлагыг өргөн ашигладаг болох нь тогтоогдсон. Харин олон улсад арилжааны банкууд нь АТМ, ПОС байгуулж, төлбөр тооцоог төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч байгууллагад төвлөрүүлж, дундын эзэмшлийн нэгдсэн сүлжээ үүсгэж, давхардсан зардлыг бууруулах илүү дэвшилтэт бүтээгдэхүүн үйлчилгээг судалсан. |
| 3 | Г. Билгүүнгэрэл “Цар тахлын үеийн цахим банкны үйлчилгээний чанарыг сайжруулах нь   | 2017 он     | Цар тахлын үед харилцагчдын цахим банкны үйлчилгээнд хандах хандлага, уг үйлчилгээнээс авах сэтгэл ханамжийг тодорхойлон судалж, цахим банкны үйлчилгээний чанарыг харилцагчдын сэтгэл ханамжид нийцүүлэн сайжруулах талаар зөвлөмж боловсруулахад судалгааны ажлын зорилго оршино.  |
| 4 | Florence Cheronо Bett, Dr. Jared Bitange Bogonko “Relationship between digital finance technologies and profitability of banking industry in Kenya” | 2017 он     | Бүх зүйл дижиталчлагдана. Үүний тулд дотоод саад бэрхшээл, дотоод байгууллагын соёл, оновчтой шийдвэр гаргалт, хүний нөөц, ИТ, дотоод ажлуудыг орхигдуулахгүй байхын тулд эдгээр зүйлсэд ч мөн шинэ бодлого, бизнесийн загвар хэрэгтэй гэж үзсэн.  |



|   |   |         |   |
|---|---|---------|---|
| 5 | Ranjan Kumar, Yuosre Badir, Maheshwor Shrestha “Digital transformation of financial institutions and its impact on their profitability” | 2021 он | Мэдээллийн технологийн хөгжилд хамгийн их өөрчлөлт авчрах нь Санхүүгийн салбар гэж үзэн 2025 он гэхэд үйлчлүүлэгч, үйл ажиллагааны загвар, орлого, платформ, банкны үнэ цэнэ гээд тус бүрт ямар өөрчлөлтүүд бий болох боломжтой талаар судалгаа хийж, таамаглал дэвшүүлсэн. |
|---|---|---------|---|

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

## 1.2 Дижитал шилжилт

Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал нь дэвшилтэт технологид суурилсан бизнесийн шинэлэг загвар, бизнесийн шинэ моделийг бий болгож түүгээрээ аж ахуй нэгжүүдэд бүтээмжийг дээшлүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах гэх зэрэг олон давуу талыг өгч байна. 4-р хувьсгалд тоон, логик талын зүйлс буюу дижиталчлалын орчин гэж зэрэг хэлж болно.

Зураг 1.1 Аж үйлдвэрийн 4-р хувьсгал



Эх сурвалж: (Ipartner.mn, 2020)

Дэлхийн томоохон компаниудын хувьд хэн нь бэлтгэн нийлүүлэгч компаниудыг платформд нэгтгэж чадна тэр компани хүчтэй болж байна. Эдгээр компаниудад өөрийн гэсэн үйлдвэр, худалдааны сүлжээ байх шаардлага байхгүй бөгөөд платформ үүсгэн түүнийг удирдах замаар бага зардлаар өндөр орлоготой ажиллаж байна гэсэн үг юм. (Нанософт, 2018)

**Дижитал шилжилт** гэдэг нь мэдээллийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ үйл явцыг оновчтой болгох, автоматжуулах, дижитал болгох зорилгоор янз бүрийн финтек технологиудыг нэгтгэх зорилгоор банкны салбарт хийгдсэн хэд хэдэн өөрчлөлтийг хэлнэ.


Дижитал шилжилт юу санал болгодог, хэрхэн ажилладаг, үйлчлүүлэгчидтэй хэрхэн тогтмол харьцдаг зэрэг бизнесийн загварынхаа бүх хэсгийг сайжруулахын тулд технологийг ашигладаг. Дижитал өөрчлөлтийн дараагийн үе шатууд нь технологиос давж гардаг тул томоохон хэмжээний хөрөнгө оруулалт шаардаж хувь хүн болон байгууллагын түвшинд технологийг хэрхэн нэвтрүүлэх, ашиглах өөрчлөлтийг хэлнэ. Энэ нь үнэ цэнэ, хүмүүс, оновчлол, шаардлагатай технологи, өгөгдлийг ухаалаг ашиглах замаар хурдан хариу үйлдэл үзүүлэх чадвар юм. Томоохон газрууд харилцагчдын хүлээлтийг хангах, журмыг хялбарчлах, шинийг санаачлах, үр шимийг хүртэх, эрсдэл, аюул заналхийлэлд бэлтгэх, бизнесийн загварыг сайжруулах зэрэг олон зорилгод хүрэхийн тулд дижитал технологийг ашиглаж болно. Дижиталчлал нь технологийн дэвшлийн улмаас хүмүүсийн өдөр тутмын амьдралын хэв маягийг хурдан өөрчилж байна. Байгууллагын дизайн, ажил эрхлэлтийн үйл явц, боловсон хүчний менежмент зэрэг нь дагаад өөрчлөгдсөн.

Эдийн засгийн дэвшилтэт шинэчлэл, технологийн хурдацтай дэвшлийн улмаас банкны салбар дижитал эрин зуунд хурдацтай шилжилтийг туулж байна. Банкууд гар утас, таблет, интернэт зэрэг дижитал платформоор дамжуулан харилцагчиддаа төгсгөл хүртэлх үйлчилгээг үр дүнтэй санал болгодог. Банктай холбоо барилгүй, салбар дээр очилгүй, гарын үсэггүй үйлчилгээ, мөн 24 цагийн үйлчилгээг санал болгож, баярын өдрүүдэд ч хэрэглэгчдэд дансандаа нэвтэрч, санхүүгийн гүйлгээ хийх боломжийг олгодог. Дижитал өөрчлөлтийн улмаас банкуудын ажиллах хүчинд ажлын шинэ боломжууд бий болсон. Банкны ашигт ажиллагааны нийт цэвэр ашиг нь бизнес цаашид оршин тогтнох эсвэл зогсох эсэхийг тодорхойлдог бизнесийн эцсийн үр дүн юм. Үүнийг хэмжих, төлөвлөх нь хамгийн чухал. Бизнесийн бараг бүх дотоод болон гадаад өөрчлөлтийг ашигт ажиллагаатай харьцуулан шалгадаг. Бизнесийг байгаагаар нь үргэлжлүүлж чадах эсэхийг баталгаажуулах эсвэл шинэ стратеги боловсруулах шаардлагатай. "Үйл ажиллагааны ашигт ажиллагаа" нь хүлээгдэж буй өгөөжтэй илүү хүчтэй холбоог харуулж байгаа бөгөөд энэ нь ашигт ажиллагааны тухай ойлголттой илүү ойр байдаг. Судалгаанд нийт хөрөнгө, нийт борлуулалт, татварын өмнөх ашиг, үйл ажиллагааны зардал, ашгийн хэмжээ, хөрөнгийн өгөөж, өөрийн хөрөнгийн өгөөж, орлогын өртөг гэх мэт ашигт ажиллагааны хэмжүүр болгон ашигласан.

Дижитал банкны хөгжил нь эдийн засгийн нээлттэй байдлыг нэмэгдүүлж, далд эдийн засгийг бууруулж, татвар хураалт, ажлын байр нэмэгдүүлэх, ДНБ-ий өсөлтийг бий болгоно. Банк, санхүүгийн байгууллага нь дэлхийн бүх улс орны эдийн засгийн өсөлтийн үндэс суурь болдог. Сүүлийн жилүүдэд банкууд дижитал шилжилтэд анхаарал

хандуулж, үйл ажиллагааны зардлыг оновчтой болгохын зэрэгцээ үйлчлүүлэгчдэдээ тасралтгүй үйлчилгээ үзүүлэх дижиталчлалыг бий болгоход тасралтгүй хөрөнгө оруулалт хийж байна. Ийнхүү энэхүү судалгаа нь банкны салбар дахь дижитал шилжилт болон санхүүгийн ашигт ажиллагааны хоорондын хамаарлыг тогтоохоор зорив. Тодруулбал, Голомт банкны сүүлийн 6 жилийн санхүүгийн мэдээллийн нотолгоонд тулгуурлан зорилго нь банкны ашигт ажиллагаа ба санхүүгийн ашигт ажиллагааны хоорондын хамаарлыг судлах явдал юм.


Зураг 1.2 Ашигт ажиллагаа ба санхүүгийн ашигт ажиллагаа хоорондын хамаарал



Дижитал шилжилт нь санхүүгийн ашигт байдалд нөлөөлж чаддаг, учир нь бизнес эрхлэгчдэд өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдлэгийг дээшлүүлэх, шинэ хэрэглэгчдийг татах маркетинг, борлуулалтын шинэ сувгийг бий болгох боломжийг олгодог. Дижитал өөрчлөлт нь санхүүгийн ашигт ажиллагаанд эерэг нөлөө үзүүлдэг. Мэдээллийн технологийг зардалтай гэж айдаг ч дижитал үйлчилгээ нь гүйлгээний өртөг багатай, үйлдвэрлэл, түгээлтийн ахиу зардалгүй, хямд маркетинг, хямд менежменттэй байдаг. Үйл ажиллагааны зардалд орлого бүрдүүлэх явцад зарцуулсан хөрөнгийн бус бүх зардлууд орно. Дижитал санхүүжилтийг нэвтрүүлснээр үйлчлүүлэгчид хэрэглээний төлбөр, сургуулийн төлбөр эсвэл бусад санхүүгийн гүйлгээгээ төлөхийн тулд банкны танхимд очерлодог өдрүүдийг зогсоосон. Тэд одоо АТМ картаа ашиглан эсвэл гэрээсээ ч интернэтээр дамжуулан үүнийг хүссэн үедээ хийх боломжтой. Түүнчлэн үйлчлүүлэгчид мөнгө байршуулах, мөнгөө авах, хэрэглээний төлбөрөө төлөх, зээл авахын тулд банкны үйлчилгээний салбар руу очдог. Дижитал сувгуудтай банкууд ихэнх үйлчилгээг гар утасны програм, интернэт банк, бэлэн мөнгө байршуулах машин (CDS), автомат теллерийн машин (АТМ) ашиглан үйлчлүүлэгчдэд хүргэх боломжтой тул үйлчилгээний салбаруудад үйлчлүүлэгчдийн ачаалал эрс буурч байна. Салбарыг ажиллуулахад байрны түрээс, цахилгааны төлбөр, хүний нөөц, цалин болон бусад ажилчдын нөхөн олговор, тэтгэмж гээд асар их зардал гардаг. Үйл ажиллагааны зардал нь дижитал хувиргалт ба санхүүгийн ашигт ажиллагааны хоорондын хамаарлыг зуучилдаг. Өөрөөр хэлбэл дижитал шилжилт нь ашиглалтын зардлыг бууруулдаг бөгөөд энэ нь эргээд ашигт ажиллагааг нэмэгдүүлдэг. Дижитал шилжилт нь шинэ үнэ цэнийн санал, маркетинг, борлуулалтын шинэ сувгууд, хэрэглэгчийн амьдралын мөчлөгийн

менежментийг сайжруулснаар орлогын өсөлтийг дэмждэг. Банкууд киноны тасалбар захиалах, даатгалын бүтээгдэхүүн борлуулах, гуравдагч этгээдийн зээлийн картын төлбөр, нийтийн үйлчилгээний төлбөрийг төлөх зэрэг дижитал сувгуудаараа дамжуулан олон төрлийн үйлчилгээг үзүүлж байна. Хариуд нь банкууд эдгээр гуравдагч этгээдээс шимтгэл авдаг бөгөөд энэ нь эцсийн дүндээ тэдний орлогод нэмэгддэг.

Зураг 1.3 Банк санхүүгийн салбарт бий болсон инновацуд



Эх сурвалж (Yolt.com, 2021)

Дээрх зургаас харвал банк санхүүгийн инновац нь 1870 оноос эхлэлтэй ба өдийг хүртэл тасралтгүй хөгжсөөр байна.

Хүснэгт 1.2 Банкны салбар дахь технологийн хөгжлийн нөлөөлөл

|                 |        |                          |
|-----------------|--------|--------------------------|
| Нээлт хийсэн он | Нэршил | Тайлбар (Банкны салбарт) |
|-----------------|--------|--------------------------|


|      |  |  |
|------|--|--|
| 1836 | Pneumatic capsule transportation (Пневматик Капсулан хоолойн тээвэрлэлт) | Объектыг хоолойгоор дамжуулан зөөвөрлөх пневматик капсул системийг зохион бүтээснээр Шотландын инженер, зохион бүтээгч Уильям Мердок нь программ хайх ажилд шинэ технологи нэвтрүүлжээ. Пневматик капсулыг эхлээд телеграмм дамжуулахад ашигладаг байсан боловч автомашины эрин үе эхлэхэд Америкийн банкнууд уг шинэ бүтээлийг хүлээн авснаар үйлчлүүлэгчид машинаа орхихгүйгээр мөнгөө татан авч, гүйлгээний (хадгаламж) үйлчилгээ авах боломжтой болжээ.  |
| 1950 | The credit card (Кредит карт)  | "Diners Club" нь олон улсын гишүүн байгууллагуудад ашиглах боломжтой зөөврийн төлбөрийн шийдэл болох анхны бүх нийтийн зээлийн картыг нэвтрүүлэв.  |
| 1967 | The ATM (АТМ)  | Их Британийн мега банк Барклайс 1967 оны 6-р сарын 27-нд Лондон хотын захад анхны АТМ-ыг байршуулжээ. Компьютерын дэлгэц, соронзон тууз карт, PIN код, харилцагчийн данс, дансыг дэлхийн банкнуудын сүлжээнүүдтэй холбосон алгоритмууд. "Эдгээр сүлжээний стандартууд нь бидний мэддэг төлбөрийн экосистемийг идэвхжүүлдэг гол сүлжээ, үндэс суурь байсан юм" Цаг хугацаа өнгөрөх тусам АТМ-ны ажил урагшилсаар байв.  |
| 1973 | FTP (file transfer protocol) (Файлыг шилжүүлэх протокол)                 | Компьютер судлаач J.C.R компани анх танилцуулсан бөгөөд Ликлидер АНУ-ын Батлан хамгаалах яамны Дэвшилтэт судалгааны төслүүдийн агентлагийн сүлжээ (ARPANET) -г ихэвчлэн компьютерууд хоорондоо хэрхэн сүлжээгээр холбох тухай ойлголт юм. АСН сүлжээнд "Хэрэглэгчид уян диск эсвэл АСН мэдээлэл бүхий соронзон хальсаар удирдах боломжтой" гэж Бассс хэлжээ. Интернет нь улам хөгжих хандлагыг бий болгосон бөгөөд үүлэн тооцоолол болон API (программын интерфэйс) нэмэгдсэн нь ARPANET-ийн ажлын үр дүн нь бодит цагийн төлбөр (RTP) боловсруулалтыг банкирууд удирдаж ашиглах болсон байна. |
| 1980 | Electronic cash counters (Электрон мөнгө тоологч машин)                  | Их Британид тоолуур машиныг анх нэвтрүүлж, банкны нярвуудын ажлыг маш ихээр хөнгөвчилсөн.  |
| 1989 | Tablet computers (Таблет)  | GRiD Systems-ээс гаргасан бөгөөд Samsung-ийн үйлдвэрлэсэн GRiDPad нь арилжаагаа амжилттай явуулсан анхны таблет гэж тооцогддог. Таблетууд нь банкны ажилтнуудад салбар дотор, цаашлаад салбартаа шилжих боломжийг олгодог. Теллер бэлэн болох гэж байхаар хүлээхийн оронд теллер хаалган дээр ирж, үйлчлүүлэгчтэй мэндчилж, тэдэнтэй хамт буйдан дээр суулгаад тэдний хэрэгцээг гар утасны таблетаас холбож үйлчилгээг хүргэх болох боломжтой болжээ.  |
| 1998 | PayPal (Төлбөрийн систем)  | "Confinity" нэртэйгээр байгуулагдсан PayPal нь хэрэглэгчдэд хамгийн амраар мөнгө шилжүүлэх үйлчилгээ болон анх үүсжээ.   |

|      |  |   |
|------|--|---|
| 2004 | Digital check clearing (Электрон чек)                      | Checking Clearing (Check 21) тухай хуулийн дагуу чек хүлээн авагч нь чекийн дижитал хэлбэрт оруулан, шалгалтыг электрон хэлбэрээр хийх замаар санхүүгийн үйлчилгээг хурдасгах болжээ. Тус дижитал чек шалгах үйлчилгээ нь "маш их цаас хэмнэж, олон тооны шуудан зөөгчдийг бизнесээс гаргаж чаджээ. Дижитал чек шалгалт нь төлбөр тооцоог цаг тухайд нь хийдэг шинэчлэлийн эхлэл байсан юм. Энэ нь илүү хурдан мөн хялбар болсон.   |
| 2007 | The iPhone (Ухаалаг гар утас)                              | Стив Жобс 2007 оны 1-р сарын 9-ний өдөр Макворлд болсон чуулганаар iPhone-ий нээлтийг хийжээ. Таван сар хагасын дараа анхны iPhone худалдаанд гарав. Apple Inc. нь гар утасны төлбөрт шилжих боломжтой гэсэн бөгөөд 2014 оны 9-р сарын 9-ний өдөр Apple Pay нэвтэрснээр, гар утасны төхөөрөмжийн тусламжтайгаар төлбөрийн картын мэдээллийг оруулах замаар төлбөр хийх боломжтой болжээ.  |
| 2009 | Bitcoin (Биткойн)  | Bitcoin нь cryptocurrency юм. Энэ нь төв банк эсвэл дан админгүйгээр төвлөрсөн бус дижитал валют бөгөөд хэрэглэгчдийг биткойн сүлжээнд дундын зуучлалгүйгээр мөнгөн шилжүүлгийг блокчэйн технологийн тусламжтайгаар гүйцэтгэх боломжтой юм.   |
| 2010 | Mobile point-of-sale devices (Мобайл төлбөр тооцоо)        | Гар утас эсвэл iPad-тай холбож болох эдгээр төхөөрөмжүүд нь маш жижиг компаниудад тариалангийн зах дахь жимсний тариаланчдаас эхлээд үзэсгэлэн худалдаа дээр гар урлал эрхлэгчид хүртэл бэлэн бус төлбөр хүлээн авах боломжийг олгосон юм.  |
| 2011 | Facial recognition technology (Нуур царай таних технологи) | Панамын засгийн газар Tocomen олон улсын нисэх онгоцны буудлын хууль бус үйл ажиллагааг бууруулах зорилгоор 2011 онд нүүр царайг таних системийг анх суурилуулсан. Сүлжээний видео зах зээлийн тэргүүлэгч Axis Communications, Inc. компаний бизнес хөгжлийн менежер Стивен Жозеф видео аналитик нь аюулгүй байдлыг сайжруулахыг эрэлхийлж буй банкнуудын анхаарлын төв болж байна гэж тэмдэглэжээ. Санхүүгийн байгууллагууд "болзошгүй аюулыг урьдчилан илрүүлэх зорилгоор" 360 градусын камер, нүүрний мэдрэгчийг илрүүлэх шийдлүүдийг ашиглаж байгааг тэмдэглэжээ. |
| 2015 | The 2015 EMV chip shift (EMV чип)                          | EMV чипууд нь картуудыг илүү найдвартай болгодог учир нь дамжуулагдсан мэдээлэл шифрлэгдсэн байдаг байна. Картын төлбөр тооцоог илүү нарийн бөгөөд аюулгүй байдлыг хангахад чипний гол зорилго оршино.  |

|      |   |   |
|------|---|---|
| Одоо | Дижитал банк, Big data,Дата олборлолт, Дата анализ, Ухаалаг оюун ухаан /AV/. Апп, Веб хуудас, Нээлттэй API, Онлайн банк, Блокчэйн, Финтек | Технологийн хурдацтай хөгжилд бий болсон эдгээр ойлголтууд нь банкны харилцагч нарт бүтээгдэхүүн үйлчилгээг гар утас, интернэт банкаар дамжуулан асар хурдацтайгаар хүргэж байгаа бөгөөд дижитал банкны эко системийн хөгжил удахгүй хэрэгжих боломж бүрдсэн байна. |
|------|---|---|

Эх сурвалж (Elizabeth Judd, 2017)

Зураг 1.4 Монгол Улсын интернэт хэрэглэгчдийн тоо



Эх сурвалж (ikon.mn, Интернэт хэрэглэгчдийн тоо, 2022)

Дээрх зураг 3-д нийт интернэт хэрэглэгчдийн тоо 2.16 сая байгаа нь нийт хүн амтай харьцуулахад 64.4 хувийг эзэлж, өмнөх жилээс 4.7 хувиар өссөн байна.

Өнөөдрийн цахимжилт, дижиталчиллын түвшинд хүрэхийн тулд Монгол Улс дараах шат дараатай үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж иржээ.

1. “Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги” (2002-2006), (Засгийн газрын 2002 оны 233-р тогтоол)
2. “Мэдээлэл, холбооны технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал”, (Засгийн газрын 2000 оны 21-р тогтоол)
3. “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр 2005-2012 (Засгийн газрын 2005 оны 216-р тогтоол)
4. Монгол улсад бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр 2008-2012 (Засгийн газрын 2008 оны 78-р тогтоол)
5. “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр” (2010-2015), (Засгийн газрын 2010 оны 141-р тогтоол)
6. “Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ үндэсний хөтөлбөр” (2011-2015), (Засгийн газрын 2010 оны 145-р тогтоол)

7. “Цахим засаг” үндэсний хөтөлбөр 2012-2016 (Засгийн газрын 2012 оны 101-р тогтоол)
8. Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017-2025, (Засгийн газрын 2017 оны 47-р тогтоол)
9. “Цахим засаглал” үндэсний хөтөлбөр 2019-2022 (Засгийн газрын 2019 оны 73-р тогтоол) (emongolia, 2020)

### 1.3 Хууль эрх зүй болон төрийн зохицуулалт

2002 оны 12-р сард батлагдсан Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль нь “Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ”-г Монгол банкаас тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж явуулж болно гэж заасан нь өдгөө мөрдөж байгаа ганц хууль эрхзүйн акт болно.

Банкны цахим үйлчилгээг эрхлэхтэй холбоотой хууль, эрх зүйн баримт бичгүүд: Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хорооноос Монгол улсад хөдөлгөөнт банкны үйлчилгээ эрхлэхэд тавих шаардлага, оролцогийн эрх үүрэг, нууцлал аюулгүй байдал, найдвартай тасралтгүй байдлыг хангах, түүнд хяналт тавихтай холбоотой дараах бодлого, журмуудыг баталжээ. Цахим банкны үйлчилгээний хувьд доорхи бодлого журмаас гадна банкны бусад холбоотой хууль, эрх зүйн баримт бичгийг мөрдлөг болгон ажиллана. Үүнд:

I. Журам: "Хөдөлгөөнт банкны журам" (Монголбанкны ерөнхийлөгчийн 2014 оны 12-р сарын 24-ны өдөр батлагдсан)

II. Бодлого: "Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлого" (Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга нарын хамтран 2012 оны 12-р сарын 14-ны өдрийн баталсан) Энэ бодлоготой хамт МонголБанкны хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг зааж өгсөн. Үүнд: Төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч оператор байгууллагыг байгуулах заалт бий..

III. Хууль: Хууль эрхзүйн хүрээнд энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгчид тухайлсан хуулийн зүйл заалт байхгүй. Харин 2018 оны 01 сарын 01-ээс хэрэгжих Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд Оператор байгууллагын үйл ажиллагааны талаар зүйл заалт тусгаж өгсөн нь төлбөрийн системийг шинэ шатанд гаргав

Төв банк Үндэсний төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг удирдах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, оролцогчдын тэгш, тэнцвэртэй оролцоо, системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах зарчмыг баримтлан төлбөрийн системд тавих хяналтыг хэрэгжүүлж, төлбөрийн системийг сайжруулах замаар санхүүгийн салбарын дэд бүтцийн хөгжлийг шинэ түвшинд хүргэхэд чиглэсэн дараах ажлуудыг онцолж байна. Үүнд:



Токен үйлчилгээний системийг нэвтрүүлж, хэрэглэгч картаа биет бусаар ашиглан төлбөр тооцоо гүйцэтгэх нөхцөлд картын мэдээлэл алдагдах, хуурамч залилангийн гүйлгээ гарах эрсдэлээс хамгаалагдлаа. Мөн төлбөрийн системийн нийт оролцогч дэд бүтэцдээ давхардсан хөрөнгө оруулалт хийх шаардлагагүй бөгөөд техник, программ хангамжийн ашиглалт, үйлчилгээтэй холбоотой зардал хэмнэгдэхийн зэрэгцээ нэгдсэн системээр төлбөр тооцоо гүйцэтгэх боломжийг бүрдүүлэв.

Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр банкууд, финтек компаниуд болон төлбөрийн системийн оролцогч бүх талтай хамтран хэрэгжүүлсэн “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийн үр дүнд төлбөр тооцооны системийн хувьд дэлхийн жишигт хүрч, олон улсын санхүүгийн системтэй нэг ойлголцолд хүрлээ. Үндэсний төлбөрийн эко системийн үүрэг бол оролцогч талуудын санхүүгийн харилцааг найдвартай, тасралтгүй, нууцлалтай, уян хатан, нэг хэл дээр зохицуулахад оршдог. Банк санхүү, финтек, хөрөнгийн зах зээл, төрийн үйлчилгээ болон бизнесийн байгууллагууд зэрэг оролцогч талууд төлбөр тооцооны нэг экосистемтэй болсноор төлбөр тооцооны өртөг буурч, санхүүгийн салбарын бүтээмж өсөж байна.

Цахим банкны үйлчилгээний үндсэн 6 функц байдаг. Үүнд

1. Мөнгө шилжүүлэх, хүлээн авах
2. Төлбөр төлөх, бараа үйлчилгээ худалдан авах
3. Дансны мэдээлэл
4. Хэрэглэгчийн мэдээлэл
5. Хөрөнгө оруулалтын үйлчилгээ
6. Лавлах үйлчилгээ зэрэг болно.

#### 1.4 Цахим банкны Монгол дахь өнөөгийн нөхцөл байдал

Интернэт хэрэглэгчдийн тоог 2022 оны хөдөлгөөнт банкны тайлангаар харуулав.


Зураг 1.5 Интернэт хэрэглэгчдийн тоо



Эх сурвалж (Хөдөлгөөнт банкны тайлан, 2022)

Нийт интернэт хэрэглэгчдийн эзлэх хувийг хот болон хөдөө орон нутгийн хэмжээнд харьцуулан харуулав.


Зураг 1.6 Хэрэглэгчдийн эзлэх хувь



Эх сурвалж ( Хөдөлгөөнт банкны тайлан, 2022)


Нийт интернэт банкны гүйлгээний төрлийг эзлэх хувиар нь харуулав.

Зураг 1.7 Нийт гүйлгээний тоонд эзлэх хувь



Эх сурвалж ( Хөдөлгөөнт банкны тайлан, 2022)

Зураг 1.8 Монголын арилжааны банкуудын нийт активын үзүүлэлт



Эх сурвалж (Хөдөлгөөнт банкны тайлан, 2022)

Монголд үйл ажиллагаа явуулж буй банкуудын зах зээлд эзлэх хувь болон активыг харьцуулав.

- Гар утасны аппликейшн 89.2%
- Цахим хуудас 10.8 %

Тус үзүүлэлтээс харахад системийн 3 банк нь Монгол Улсын арилжааны банкнуудын томоохон төлөөлөл бөгөөд банкны салбарын нийт активын 61% эзэлж байна. Тус судалгааны ажлаар системийн том-3 банкиг технологийн тэргүүлэгч байгууллагын төлөөлөгч хэмээн голчлон судалж, дижитал шилжилтийн нөлөөлөл, үйл ажиллагааны онцлогуудыг судалсан болно.

## II БҮЛЭГ. ӨНӨӨГИЙН САЛБАРЫН СУДАЛГАА

### 2.1 Голомт банкны товч танилцуулга

Голомт банк нь 1995 оны гуравдугаар сарын 6-ны өдөр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн салбарт томоохон байр суурийг эзэлдэг “Бодь интернэшнл” ХХК-ийн охин компани болон үүсгэн байгуулагдсан бөгөөд арилжааны болон хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагч, дотоод гадаадын харилцагч, түншүүддээ өндөр түвшинд хүргэн ажиллаж байна. Эх орны хөгжлийн түүчээ, иргэн бүрийн аз жаргалтай амьдралын төлөө “Сайн сайхныг санхүүжүүлнэ” уриан дор үйл ажиллагаагаа явуулдаг Голомт банк нь Монголын ууган арилжааны банкнуудын нэг юм.



| Алсын хараа                 | Эрхэмсэг оршихуй |
|-----------------------------|------------------|
| Дэлхийн жишиг Монголын банк | Хөгжлийн Голомт  |

#### Анхдагч банк

Голомт банк нь байгуулагдсан цагаасаа хойш Монголын банк санхүүгийн салбарын хөгжилд хурд нэмсэн, олон шинэ алхмуудыг хийж, дэвшилтэт, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсад анхлан нэвтрүүлсээр ирсэн. Үүнд:

- ✓ Олон улсын төлбөрийн картын систем
- ✓ Интернэт банк, 24 цагийн банкны үйлчилгээ, явдаг АТМ

- ✓ Мөнгөн гуйвуулгын Western Union үйлчилгээ
- ✓ Хосолсон валют бүхий Dual Currency карт
- ✓ БНХАУ-ын нутаг дэвсгэрээс гадна дэлхийн зах зээлд анх удаа нэвтэрсэн UnionPay юанийн карт
- ✓ Ухаалаг утсанд суурилсан банкны аппликэйшн болох Смарт банкны үйлчилгээ
- ✓ American Express®Goldcard, American Express®Greencard
- ✓ Харилцагч өөрийн амьдралын хэв маяг, санхүүгийн хэрэгцээнд нийцүүлэн сонгох боломжтой Сонгодог карт
- ✓ Монгол Улсын 2016 оны шилдэг инновац нэвтрүүлэгч онцлох энтрепренерээр өргөмжлөгдсөн Зэс кредит карт, дараа төлбөрт Ган карт
- ✓ Дэвшилтэт технологид суурилсан финтек бүтээгдэхүүн болох SocialPay дижитал хэтэвч зэрэг шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг эрхэм харилцагчдадаа хүргэн ажиллаж байна.

Голомт банк дэвшилтэт технологийг салбартаа түүчээлэн нэвтрүүлдгийнхээ хувьд ухаалаг утас ашиглан нэг минутын дотор зээл авах технологийг 2019 онд анхлан үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр харилцагчдын цаг завьг хэмнэсэн ухаалаг шийдэл болов.

Өнөөдрийн байдлаар Голомт банкны SocialPay дижитал хэтэвчийг 320 мянга орчим хэрэглэгч идэвхтэй ашиглаж байна. (lemonpress.mn, 2022)

#### Хүснэгт 2.1 Голомт банкны дижитал нэвтрэлт




| Огноо | Тайлбар                               |
|-------|---------------------------------------|
| 1996  | Голомт чек-ийн үйлчилгэн нэвтрүүлсэн. |
| 1999  | Анхны ОУ-ын карт нэвтрүүлсэн.         |
| 1997  | 24 цагийн банкны үйлчилгээ.           |
| 1999  | Анхны ОУ-ын карт нэвтрүүлсэн.         |
| 2000  | Visa карт.                            |
| 2001  | Телефон банкны үйлчилгээ.             |

|      |  |
|------|--|
| 2002 | Анхны интернэт банкны үйлчилгээ (Картын мэдээлэл авах).  |
| 2004 | Монголд анх удаа соронзон тууз бүхий хадгаламжийн дэвтэр нэвтрүүлэв.   |
| 2006 | АТМ - Бэлэн мөнгөний машин нэвтрүүлэв.   |
| 2008 | EMV chip карт  |
| 2012 | Өөртөө үйлчлэх CDM.  |
| 2014 | Финакл банкны үндсэн систем.   |
| 2016 | American Express E Green Card болон Зэс картыг зах зээлд   |
| 2017 | Төлбөр тооцоог хөнгөвчилсөн SocialPay үйлчилгээг нэвтрүүлэв.   |
| 2018 | <ul style="list-style-type: none"> <li>• Онлайн худалдааг хялбарчилсан SocialPay үйлчилгээний шинэ боломжийг танилцуулав.</li> <li>• Онлайн ертөнцөд ашиглах боломжтой Виртуал картыг зах зээлд гаргав</li> </ul>  |
| 2019 | <ul style="list-style-type: none"> <li>• NFC технологийг нэвтрүүлэв</li> <li>• SocialPay үйлчилгээг мобайл хэтэвч хувилбар луу шилжүүлж. POS машин дээр худалдан авалт хийх боломжтой болсон</li> <li>• Монгол улсад анх удаа Дата анализ (AI) дор суурилсан "Миний санхүү" үйлчилгээг танилцууллаа.</li> <li>• Хиймэл оюун ухаан болон Шинэчлэгдсэн Интернэт банк, Смарт банкны үйлчилгээг нэвтрүүлэв.</li> </ul>   |
| 2020 | <ul style="list-style-type: none"> <li>• Олон улсын төлбөр тооцоо – Сошиал Пэй нь олон улсын төлбөр тооцоо хийх боломжтой Монгол Улсын анхны дижитал хэтэвч болсон.</li> <li>• UnionPay сүлжээний виртуал карт- Сошиал Пэй виртуал картад UnionPay картын сүлжээ нэмэгдсэн. Ингэснээр UnionPay сүлжээнд нэгдсэн олон улсын болон Монгол Улсын худалдаа, үйлчилгээний байгууллагууд, онлайн худалдааны сайтуудаас виртуал картаа ашиглан гүйлгээ хийх боломжтой болов.</li> <li>• Хүүхдийн сошиал пэй - The Color карт эзэмшдэг 7-17 насны харилцагч нарын санхүүгийн хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор шинээр зах зээлд гаргав.</li> <li>• Бусад аппликейшнаас сошиал пэй -ээр төлбөрөө төлөх - UBCab, Onefit, Skygo, LookTV, Skytel, Mobicom, MonPay, Mongolchat, Toki, Hiprocards, Tomyo, Toktok, ENomin, Emart, Storepay гэх зэрэг нийт 30 гаруй үйлчилгээ үзүүлэгч аппликейшнуудыг сошиал пэй дижитал хэтэвчтэй холбон, төлбөр тооцоогоо хийх боломжтой болов.</li> </ul> |

Эх сурвалж: Судлачийн боловсруулснаар

## 2.2 Банкуудын дижитал бүтээгдэхүүний танилцуулга ба харьцуулалт

Хүснэгт 2.2 Дижитал бүтээгдэхүүний танилцуулга ба харьцуулалт

|  |   |  |
|--|---|--|
| <p>Socialpay-Голомт банк</p>    | <p>Pass.mn- Хаан банк</p>   | <p>Most money- ХХБ,<br/>Капитрон</p>    |
| <p>Харилцагч уламжлалт бус дижитал банкны бүтээгдэхүүн үйлчилгээ рүү хөтлөгдөж, сошиал харилцааг илүүд үзэж буй энэ цаг үед Голомт банк нь Монгол Улсад анх удаа SocialPay финтех үйлчилгээг амжилттай нэвтрүүлэв.</p>   | <p>Банкны төлбөрийн картуудаа аппликэйшнд холбон, төлбөр тооцоог хамгийн хурдан, хялбараар хийх боломжтой.</p>  | <p>Хүн өөрийн өдөр тутмын санхүү, төлбөр тооцооны хэрэгцээгээ хангах боломжтой бөгөөд олон санхүүгийн байгууллагын дансаа нэг дороос удирдах боломжтой.</p>  |
| <ul style="list-style-type: none"> <li>• Цагийг хэмнэх, санхүүгийн өдөр тутмын төлбөр тооцоог хялбараар шийдэх үйлчилгээ</li> <li>• Утасны дугаар, и-мэйл хаяг, facebook болон GPS байршил ашиглан мөнгө илгээх, нэхэмжлэх боломжтой.</li> <li>• Хувийн чат үүсгэн харилцах, чатлах явцдаа мөнгөн шилжүүлэг хийх боломжтой.</li> <li>• Дэлгүүр, үйлчилгээний байгууллагуудад утасны дугаараар болон QR код уншуулан төлбөр тооцоо хийх боломжтой.</li> <li>• Харилцагч болохын тулд заавал банкны салбар орох шаардлагагүй, онлайнаар бүртгүүлэх боломжтой.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Карт болон бэлэн мөнгөгүйгээр төлбөр тооцоогоо хийх боломжтой.</li> <li>• ПОС төхөөрөмж дээрх QR кодыг уншуулаад л тооцоогоо хийнэ.</li> <li>• Олон улсын аюулгүй байдлын стандарт хангасан өндөр нууцлалтай.</li> <li>• Төлбөр тооцоо хийхдээ гар утсаараа QR кодыг зайнаас уншуулна. Хүрэлцэх болон дамжуулах шаардлагагүй.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>• Шилжүүлэг (Дурын банкны данс руу шилжүүлэг хийх)</li> <li>• Төлбөр (Урьдчилсан болон дараа төлбөрт үйлчилгээний төлбөр төлөх)</li> <li>• Худалдаа (Онлайн болон дэлгүүр дээр худалдаа хийх)</li> <li>• Бэлэн гүйлгээ (АТМ -ээс мөнгө авах, Банкны салбар дээр мөнгө авах, хийх)</li> <li>• Онлайн зээл (Кредит оноон дээр үндэслэн онлайнаар зээл олгох)</li> </ul> |

|   |  |  |
|---|--|--|
| <ul style="list-style-type: none"> <li>• SocialPay данс дээр ОУ-ын гүйлгээний эрхтэй виртуал карт автоматаар үүсэх ба тухайн картаар онлайн худалдан авалт хийх бүрэн боломжтой.</li> </ul> |  |  |
|---|--|--|

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

SocialPay дижитал хэтэвчийг банк санхүүгийн салбарт хамгийн өргөн хэрэглэж, зөвхөн төлбөр тооцоо хийгээд зогсохгүй хэрэглэхэд хялбар байдлаараа хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагыг хангаж, жил ирэх тусам олон талаар улам өргөжиж байна.

### 2.3 Голомт банк- Сошиал Пэй дигитал хэтэвчийн инновац

**2017 он** - Харилцагч уламжлалт бус дижитал банкны бүтээгдэхүүн үйлчилгээ рүү хөтлөгдөж, сошиал харилцааг илүүд үзэж буй энэ цаг үед Монгол Улсад анх удаа сошиал пэй финтек үйлчилгээг амжилттай нэвтрүүлээд байна. Ухаалаг гар утсанд суурилсан тус аппликейшний тусламжтайгаар facebook, twitter, и-мэйл хаяг болон утасны дугаар нь бүртгэлтэй хүмүүсийн жагсаалт, байршлыг ашиглан хамгийн хялбар аргаар төлбөр тооцоо гүйцэтгэх боломжийг харилцагчдадаа олгосон юм.

#### 2018 он

2018 оны 12 сарын байдлаар Монгол Улсын хамгийн их таталттай мобайл аппликэйшн болж чадав

- ✓ Хэрэглэгчийн тоо өмнөх онтой харьцуулахад 3 дахин нэмэгдэв.
- ✓ 34 мянган иргэн салбарт ирэхгүйгээр банкны харилцагч болов.
- ✓ Сард дунджаар 80 мянган ширхэг гүйлгээ хийгдэв.
- ✓ 10 гаруй мянган виртуал дебит карттай болж, бүх төрлийн картын бэлэн бус үйлчилгээнд ашиглаж байна.
- Дижитал хэтэвчээр дамжуулан шинээр банкны харилцагч болох, харилцах, хадгаламжийн данс нээх, бүх төрлийн төлбөр тооцоонд ашиглах олон улсын эрхтэй ВИРТУАЛ картыг үнэ төлбөргүй авах, төлбөр тооцоо хийх боломжтой болсон.



- Интернет худалдааны үйлчилгээ үзүүлдэг Монгол Улсын дийлэнх байгууллагууд сошиал пэй дижитал хэтэвчинд нэгдсэн бөгөөд харилцагч онлайн төлбөр тооцоогоо хамгийн хялбараар хийх боломжтой болов.

Зураг 2.1 Дижитал шилжилтийн 2018 оны тайлан



Эх сурвалж (тайлан, 2018)

- **2019 он-** Харилцагчид дурын банкны картаа Голомт банкны дижитал хэтэвч SocialPay аппликэйшнд бүртгүүлэн төлбөр тооцоондоо шууд ашиглах боломжтой болсон нь банкны салбартаа анхдагч болсон.
- ✓ Хэрэглэгч худалдан авалт хийхдээ дижитал хэтэвчээрээ QR код ашиглан төлбөр тооцоо хийх боломжийг анхлан нэвтрүүлснээр SocialPay дээрх дурын картыг сонгон төлбөр тооцоогоо хийх боломжтой боллоо.
- ✓ Монголын анхны олон улсын эрхтэй Виртуал картыг SocialPay аппликэйшнд амжилттай нэвтрүүлснээр харилцагч заавал салбар дээр өөрийн биеэр картаа захиалан авч, төлбөр тооцоондоо ашиглах байдлыг дараагийн шатанд гаргалаа.

SocialPay ашиглан төрөл бүрийн үйлчилгээг авах боломжтой болов. Үүнд:

- Олон улсын нислэгийн билет
- Олон улсын төмөр замын билет
- Монгол орон даяар амралт болон зочид буудал
- Бүх төрлийн үзвэр үйлчилгээний тасалбар
- Бүх кино театруудын үзвэрүүд
- Цаг үеийн тренд фестивал, үзвэр үйлчилгээ

Зураг 2.2 Дижитал шилжилтийн 2019 оны тайлан



Эх сурвалж (Голомт банк жилийн тайлан)

- **2020 он**
- ✓ Олон улсын төлбөр тооцоо – Сошиал Пэй нь олон улсын төлбөр тооцоо хийх боломжтой Монгол Улсын анхны дижитал хэтэвч боллоо. EMV UPI Standard QR/Bar code-г сошиал пэй дижитал хэтэвчээр дамжуулан Хятад, Сингапур, Тайвань, Хонг Конг, Орос, Австрали зэрэг 50 гаруй улс орнуудын сүлжээ дэлгүүр, үйлчилгээний байгууллагууд дээр худалдан авалт хийхдээ уншуулж, төлбөр тооцоогоо хялбар аргаар хийх боломжийг харилцагч нартаа олголоо.
- ✓ UnionPay сүлжээний виртуал карт – "UnionPay картын сүлжээ нэмэгдлэж UnionPay сүлжээнд нэгдсэн олон улсын болон Монгол Улсын худалдаа, үйлчилгээний байгууллагууд, онлайн худалдааны сайтуудаас виртуал картаа ашиглан гүйлгээ хийх боломжтой боллоо.
- ✓ Бүх банкны харилцагч нар сошиал пэй нээн ашиглах – Голомт банканд дансгүй болон сошиал пэйгүй харилцагчид ердөө утасны дугаар, овог, нэр, регистрээ бүртгүүлэн бусад банкны картаа холбон ашиглах боломжтой боллоо.
- ✓ Хүүхдийн сошиал пэй – The Color карт эзэмшдэг 7-17 насны харилцагч нарын санхүүгийн хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор Хүүхдийн "SocialPay" үйлчилгээг шинээр зах зээлд гаргалаа.

- ✓ Бусад аппликейшнаас социал пэй ашиглан төлбөрөө төлөх – UBCab, Onefit, Skygo, LookTV, Skytel, Mobicom, MonPay, Mongolchat, Toki, Hippocards, Tomyo, Toktok, ENomin, Emart, Storepay гэх мэт нийт 30 гаруй үйлчилгээ үзүүлэгч аппликейшнуудыг социал пэй дижитал хэтэвчтэй холбон, төлбөр тооцоогоо хийх боломжийг бүрдүүллээ.

Зураг 2.3 Дижитал шилжилтийн 2020 оны тайлан



Эх сурвалж (Голомт банк жилийн тайлан)

- **2021 он**
- ✓ SocialPay дижитал хэтэвчинд гуравдагч байгууллагуудын лоялти картуудыг нэмэх боломжтой болов. U-Point, И март, Сансар, Оргил зэрэг дэлгүүр, үйлчилгээний байгууллагын бонус картаа биетээр авч явах шаардлагагүй болж, хэтэвчиндээ лоялти картаа бүртгэн хөнгөлөлтийн оноогоо цуглуулж, хялбар зарцуулах боломжтой юм.
- ✓ Нээлттэй банкны стратегийн хүрээнд SocialPay аппликэйшнээс Mongol chat аппликэйшны хэрэглэгч рүү шилжүүлэг хийх боломжийг нэвтрүүлсэн бөгөөд хэрэглэгчид Mongol chat аппликэйшн дээр харагдах QR кодыг SocialPay аппликэйшнээр уншуулж, дурын картаа сонгон гүйлгээ хялбар хийх боломжтой боллоо.
- ✓ SocialPay аппликэйшнээс өөрт байгаа Оноо, Сугалаа, Cashback, Купоны мэдээллээ харах, Лоялти дансаа удирдах, банкнаас зарласан урамшуулалт хөтөлбөрүүд, хөнгөлөлтийн сүлжээний нэгдсэн мэдээллийг авах боломжтой боллоо.

Зураг 2.4 Дижитал шилжилтийн 2021 оны тайлан

26% ▲ СошиалПэй нийт хэрэглэгчийн тоо

59% ▲ СошиалПэй идэвхтэй хэрэглэгчийн тоо


35% ▲ СошиалПэй нийт гүйлгээний тоо

Эх сурвалж (Голомт банк жилийн тайлан)

- 2022 он

2022 оны байдлаар тухайн дижитал хэтэвчийн “Нэмэлт Цэс” хэсэгт дараах зүйлс багтаж байна.

Зураг 2.5 SocialPay дижитал хэтэвчийн функцууд



Эх сурвалж (Голомт банк жилийн тайлан)

Нэмэлт цэс хэсэгт байрлаж буй бүтээгдэхүүн үйлчилгээнд:

- Виртуал карт- Онлайн худалдааны сайтуудаас худалдан авалт хийх боломж
- Эрүүл мэнд-Икlinik платформоор дамжуулан онлайн зөвлөгөө авах боломж
- Дата нэгж авах- Ямар ч үүрэн телефоны хэрэглэгч нэгж худалдан авах боломж
- Лоялти хөтөлбөр- Лоялти цэсийн тусламжтай Голомт банкны харилцагчид аливаа зарлагдсан урамшуулалт хөтөлбөрт хамрагдсанаар өөрт цугларсан мөнгөн урамшуулал, урамшууллын эрх болон онооны мэдээллийг дэлгэрэнгүй харах, шалгах боломжтой.

- Татвар, торгууль- Машины дугаараа оруулан татвар, торгуулийн мэдээллээ авах, төлбөрөө төлөх боломжтой.
- Хамт олон- Найз нөхөд, хүрээлээрээ шилэн данс нээн, төлбөрөө хувааж төлөх, мөнгө цуглуулах боломжтой.
- Хэрэглээний төлбөр- Интернэт, кабель, цахилгааны төлбөрийг утаснаасаа төлөх боломж
- Хувьцаа арилжаа- Голомт Капитал ҮЦК ХХК, Инвескор Капитал ХХК-аар дамжуулан зах зээлд зарлагдсан хувьцааны захиалга өгөх боломжтой.
- Хүслийн жагсаалт- Өөрийн зорилго болон биелүүлэх хүсэлтэй хугацаагаа оруулан, хуримтлал үүсгэх боломжтой.
- Зорчигч тээвэр- Төмөр зам, агаарын тээврийн тасалбарыг худалдаж авах боломжтой.
- Даатгал- Даатгалын байгууллагуудаас сонгон, өөрт тохирох даатгалын үйлчилгээ авах боломжтой.
- Үзвэр үйлчилгээ- Дэлгэцээр гарч буй болон тоглогдож буй шинэ үзвэр үйлчилгээний тасалбарыг худалдан авах боломжтой.
- Хандив- “Ид шидийн орон”, “Зүрх Мартахгүй” гэх мэт төсөлд хандив өгөх боломжтой зэрэг болно

## 2.4 Олон улсын дижитал шилжилтийн чиг хандлага

Олон улсын чиг хандлагаар дижиталжуулах стратеги нь одоо байгаа бүтээгдэхүүн, зах зээлийн чадавхийг сайжруулахад чиглээд зогсохгүй дижиталжуулах дэд бүтцийг бий болгоход чиглэгдэх ёстой.

Зураг 2.6 Арилжааны банкуудын дижитал хандлага



Эх сурвалж (Голомт банк жилийн тайлан)

Банкууд дижиталчлалын саад бэрхшээлийг тодорхойлсноор санхүүгийн хөрөнгө, хүний нөөц, технологийн чадавхийг хуваарилж, дижитал платформыг бий болгож, бүтээгдэхүүн үйлчилгээгээ үе шаттайгаар шинэчилж, санхүүгийн эрсдэлийг үр дүнтэй хянах, маркетингийн шинэлэг арга хэрэгслийг хөгжүүлэх боломжтой. (Lihua Zuo, 2021)

## III БҮЛЭГ. ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

### Зорилго:

Голомт банкны социал пэй бүтээгдэхүүн үйлчилгээний орлого зардал нь санхүүгийн тайланд нөлөөлдөг хэсэгт ашигт ажиллагаа, тэдгээрт нөлөөлөгч хүчин зүйлүүдийг судалж, ашигт ажиллагааны түвшинг үнэлж улмаар дээшлүүлэх боломжийг тодорхойлох.


### Зорилт:

- ✓ Голомт банкны ашигт ажиллагааны өнөөгийн байдлыг судлах
- ✓ Дю-понтын аргаар ашигт ажиллагааны шинжилгээг хийх
- ✓ Ялгаврын тооцооны аргаар хүчин зүйлийн шинжилгээг хийх

### 3.1 ҮНДСЭН ХЭСЭГ


Голомт банк 2021 онд 25.9 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд үйл ажиллагааны ашиг (свопын нөлөөгүйгээр) 215 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 42 хувиар өссөн байна. Мөн үйл ажиллагааны зардлыг орлогод харьцуулсан харьцаа буурч 39 хувь хүрч байна.

*Зураг 3.1 Цэвэр ашиг (тэрбум төгрөг)*



Эх сурвалж (Голомт банк жилийн тайлан)


Зураг 3.2. Үйл ажиллагааны ашиг (тэрбум төгрөг)



Эх сурвалж (Голомт банк жилийн тайлан)


2021 оны ашигт ажиллагаанд своптой холбоотой 22 тэрбум төгрөгийн зардал гарсан бол актив хөрөнгийн сангийн зардал, үнэ цэнийн бууралтын зардал өмнөх онтой харьцуулахад буурч, 141 тэрбум төгрөг гарав. Зээлийн эрсдэлийн сангийн зардал өмнөх оноос 49 хувиар буурсан бөгөөд чанаргүй зээлийг байгуулсан сангаар хаах чадвар 9 нэгж хувиар өсөж 88 хувьд хүрэв.

Зураг 3.3. Свопын нөлөө (тэрбум төгрөг)



Эх сурвалж (Голомт банк жилийн тайлан)

Зураг 3.4. Сан, үнэлгээний зардал (тэрбум төгрөг)



Эх сурвалж (Голомт банк жилийн тайлан)

### 3.2 Активийн өгөөжийн шинжилгээ

Хүснэгт 3.1 Голомт банкны активын өгөөжийн шинжилгээ



| Үзүүлэлт            | Тооцох журам                                      | 2017  | 2018  | 2019  | 2020  | 2021  |
|---------------------|---|-------|-------|-------|-------|-------|
| Активын өгөөж<br>А1 | Орлого<br>Активын дундаж үлдэгдэл                 | 11.60 | 11.13 | 9.89  | 10.50 | 10.00 |
| Активын өгөөж<br>А2 | Т. Т. Ө. Ашиг<br>Активын дундаж үлдэгдэл          | 2.30  | 2.02  | 2.03  | 2.01  | 1.40  |
| Активын өгөөж<br>А3 | Т. Т. Д. Ашиг<br>Активын дундаж үлдэгдэл          | 0.02  | 0.02  | 0.02  | 0.02  | 0.01  |
| Активын өгөөж<br>А4 | Хүүгийн орлого<br>Активын дундаж үлдэгдэл         | 0.10  | 0.10  | 0.09  | 0.09  | 0.09  |
| Активын өгөөж<br>А5 | Хүүгийн орлого<br>Х. О. О. А – ын дундаж үлдэгдэл | 27.25 | 25.17 | 21.04 | 20.93 | 20.56 |

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Голомт банкны үзүүлэлтээс харвал сүүлийн 5 жилд дунджаар 1 төгрөгийн актив тутмаас дунджаар 10.62 төгрөгийн орлого (үүний 9.19 төгрөг нь хүүний орлого), 1.95 төгрөгийн татварын өмнөх ашиг, 1.51 төгрөгийн татварын дараах ашиг тус тус олсон байна. Хүүгийн орлого оруулдаг активын 1 төгрөг тутмаас 22,99 төгрөгийн хүүгийн орлого олжээ.

### 3.3 Ашигт ажиллагааны шинжилгээ

Судалгааны объект болох Голомт банкны ашигт ажиллагааны шинжилгээг Дю понтын аргаар тооцёе. Энэхүү аргын гол агуулга нь өөрийн хөрөнгийн нэг нэгжид ноогдох ашгийн хэмжээнд нөлөөлөх үндсэн хүчин зүйлүүдийг тодорхойлох явдал юм.

Үүнд:

- ✓ Өөрийн хөрөнгийн орлогот байдал - К1;
- ✓ Активын ашигт байдал - К2;
- ✓ Өөрийн хөрөнгийн үржүүлэгч - К3;
- ✓ Ашгийн марж - К4;

- ✓ Активын орлогот байдал - K5 зэрэг тооцооны болон үнэлгээний үзүүлэлтүүд орно.

Хүснэгт 3.2- оор банкны ашигт ажиллагааны хэмжээг харуулав.

Хүснэгт 3.2 Голомт банкны ашигт ажиллагааны шинжилгээ

| Үзүүлэлт  | Тооцох журам   | 2017  | 2018  | 2019  | 2020  | 2021  |
|---|--|-------|-------|-------|-------|-------|
| K <sub>1</sub> =П/К                                   | Өөрийн хөрөнгийн орлогот байдал = $\frac{\text{Татварын дараах цэвэр ашиг}}{\text{Өөрийн хөрөнгө}}$                      | 19.20 | 16.78 | 15.69 | 15.02 | 11.98 |
| K <sub>2</sub> =П/А                                   | Активын ашигт байдал = $\frac{\text{Татварын дараах цэвэр ашиг}}{\text{Өөрийн хөрөнгө}}$                                 | 1.81  | 1.54  | 1.55  | 1.52  | 1.14  |
| K <sub>3</sub> =А/К                                   | Өөрийн хөрөнгийн үржүүлэгч = $\frac{\text{Активын дундаж үлдэгдэл}}{\text{Өөрийн хөрөнгө}}$                              | 10.62 | 10.90 | 10.12 | 9.86  | 10.49 |
| K <sub>4</sub> =П/R                                   | Ашгийн марж = $\frac{\text{Татварын дараах цэвэр ашиг}}{\text{Орлого}}$  | 0.16  | 0.14  | 0.16  | 0.14  | 0.11  |
| K <sub>5</sub> =R/A                                   | Активын орлогот байдал = $\frac{\text{Орлого}}{\text{Активын дундаж үлдэгдэл}}$  | 11.60 | 11.13 | 9.89  | 10.50 | 10.00 |
| Эх үүсвэрийн зардлын түвшин                           | Эх үүсвэрийн зардлын түвшин = $\frac{\text{Нийт зардал} - \text{Татвар}}{\text{Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө}}$        | 0.13  | 0.10  | 0.08  | 0.09  | 0.09  |
| Бизнесийн үр ашгийн түвшин                            | Бизнесийн үр ашгийн түвшин<br>= Активийн өгөөж<br>– Эх үүсвэрийн зардлын түвшин  | 11.47 | 11.03 | 9.81  | 10.41 | 9.90  |
| Хүүгийн бус зардлаа хүүгийн бус орлогоор нөхөх түвшин | Хүүгийн бус зардлаа хүүгийн бус орлогоор нөхөх түвшин<br>= $\frac{\text{Хүүгийн бус орлого}}{\text{Хүүгийн бус зардал}}$ | 0.587 | 0.668 | 0.827 | 0.760 | 0.584 |
| Цэвэр хүүгийн марж                                    | Цэвэр хүүгийн марж = $\frac{\text{Хүүгийн орлого} - \text{Хүүгийн зардал}}{\text{Активын дундаж үлдэгдэл}}$              | 0.038 | 0.028 | 0.023 | 0.026 | 0.025 |

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Голомт банкны хувьд сүүлийн таван жилд үзүүлэлтүүд ийм үр дүнтэй байна. Үүнд:


- ✓ 1 төгрөгний өөрийн хөрөнгө тутмаас дундажаар 15,74 төгрөгний ашиг олсон.
- ✓ 1 төгрөгний актив тутмаас дундажаар 1,51 төгрөгний ашиг, 2,8 төгрөгний цэвэр хүүгийн орлого олжээ.
- ✓ Өөрийн хөрөнгөө дундажаар 10,4 дахин өсгөж активт байршуулсан.
- ✓ 1 төгрөгний орлого тутмын дундажаар 0,14 нь ашиг болдог.
- ✓ 2018 оны ашиг ажиллагааны бүх үзүүлэлтүүд буурсан нь / Хүүгийн бус зардлаа хүүгийн бус орлогоор нөхөх түвшингээс бусад/ харагдаж байгаа

боловч өмнөх бусад банкуудтай харьцуулахад харьцангуйгаар тогтвортой байна.

- ✓ Татан төвлөрүүлсэн хөрөнгийн 1 төгрөг тутамд дундажаар 0,1 төгрөгний зардал гаргадаг.
- ✓ Хүүгийн бус 1 төгрөгний зардал тутмын 0,69 төгрөг нь хүүгийн бус орлогоос нөхөгддөг байна.

Дараах зурагт орлого болон татварын дараах ашгийн хэмжээг харуулав.

Зураг 3.5 Голомт банкны орлого болон ашгийн хэмжээ /сая.төг/



Эх сурвалж (Голомт банк жилийн тайлан)

Графикаас харахад банкны сүүлийн таван жилийн орлого, ашиг тогтмол өссөн байна. Орлого ашгийн тогтвортой өсөлтийг хангахад ямар хүчин зүйл голлох эерэг болон сөрөг нөлөөг үзүүлснийг хүчин зүйлийн шинжилгээгээр ялгаврын тооцооны аргаар тогтооё.

### 3.4 Голомт банкны ашигт ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлийн шинжилгээ

Хүснэгт 3-д банкны ашигт ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлсэд шинжилгээ хийв.


Хүснэгт 3.3 Голомт банкны ашигт ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлийн шинжилгээ

| Суурь он / Тайлант он | 2017 / 2018 | 2018 / 2019 | 2019 / 2020 | 2020 / 2021 |
|-----------------------|-------------|-------------|-------------|-------------|
| K <sub>3</sub>        | 0.51        | -1.20       | -0.40       | 0.96        |
| K <sub>4</sub>        | 2.22        | 2.07        | 1.15        | 3.39        |
| K <sub>5</sub>        | -0.71       | -1.97       | 0.87        | -0.60       |

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Хүснэгтээс харахад K<sub>4</sub> нь эерэг нөлөө үзүүлж байна. Энэ нь орлого ашиг өсч ашигт ажиллагаа мөн өсөж байгааг илтгэж байна.


Зураг 3.6. Голомт банкны ROE харьцаа /K<sub>1</sub>/



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Банкны сүүлийн таван жилийн дундаж 15.9 байгаа нь манай улсын банкны салбарын дундажаас /дундаж нь 6.5/ өндөр байна.

Зураг 3.7. Голомт банкны ROA харьцаа /К<sub>2</sub>/




Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Дээрх зургаас харвал банкны сүүлийн таван жилийн дундаж 1.51 байгаа нь манай улсын банкны салбарын дундажаас /дундаж нь 1.23/ өндөр байна. Энэ нь манай улсын том 3 банкны нэг болохыг харуулж байна.

### 3.5 Олон улсын активын өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт

Зураг 3.8 Олон улсын активын өгөөж болон өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлт



Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

<sup>1</sup> Тайлбар: Улс орнуудын болон бүлгүүдийн санхүүгийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг ОУВС-д мэдээлсэн боломжит сүүлийн хугацаагаар нь авсан болно

Бусад бүс нутгуудтай харьцуулахад активын өгөөжийн хэмжээ 0.2-1.4 нэгжээр илүү байгаа нь ашигт ажиллагаа өндөр байгааг харуулж байна. Өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлтээрээ Өмнөд болон Хойд Америк тивийн орнууд болон Их-20 улсын дараа орсон нь манай улсын арилжааны банк болох Голомт банкны ашигт ажиллагаа өндөр байгааг харуулж байна.

### 3.6 Голомт банкны ковидын үеийн нөхцөл байдал ба санхүүгийн үзүүлэлтүүд

2020 онд дэлхий даяар цар тахал дэгдэн, улс орнуудын эдийн засаг түүний нөлөөнд өртсөн хүнд жил болж өнгөрөв. Монгол Улсын хувьд цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор хилээ хаан, дотоод хөл хорио тогтоож, үүний зэрэгцээ эдийн засгийг сэргээх, сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор зах зээлийг дэмжих,


<sup>1</sup> WHD – өмнөд ба хойд америк тивийн орнууд (Western hemisphere countries), ED – хөгжиж байгаа эдийн засагтай орнууд (emerging and developing economies), OECD-эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн орнууд(organization for economic cooperation and development), G20 их 20 орнууд (group of 20 countries), EURевропын орнууд (European countries), APD – ази, далайн орнууд(asian and pacific countries)

идэвхжлийг сайжруулах арга хэмжээ, шийдвэрүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлсээр ирсэн хэдий ч эдийн засаг 5.3%-аар буурч, ихэнх секторууд цар тахлын нөлөөлөлд бодитоор өртөв.


Иргэд, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдож, орлого тасалдсан нь зээлийн эргэн төлөлт саатаж, борлуулалт буурах шалтгаан болсон. Мөн хөл хорио тогтоосонтой холбоотой зах зээл дээрх мөнгөний урсгал, төлбөр тооцоо эрс буурч банкны салбарын хувьд ашиг орлогод шууд нөлөөлсөн жил байв. Монголбанкны зүгээс бодлогын хүүг шат дараалан буулгаж 6%-д хүргэснээр банкнууд эх үүсвэрийн хүүгээ үе шаттайгаар буулгаад байна.

2021 онд Голомт банкны нийт актив 9.6%-аар өсч 7.3 их наяд төгрөгт хүрсэн бол харилцагчийн эх үүсвэр 7.9%-аар өсч 5.3 их наяд төгрөгт хүрээд байна. Харилцагчийн эх үүсвэрийн өсөлтийг иргэдийн эх үүсвэрийн өсөлт бүрдүүллээ.

Зураг 3.9. Нийт актив (тэрбум төгрөг)




Зураг 3.10. Харилцах хадгаламж (тэрбум төгрөг)



2021 онд цэвэр зээлийн хэмжээ өнгөрсөн онтой харьцуулахад 10.2 хувиар өсөж, 3.3 их наяд төгрөгт хүрэв. Үүнд хэрэглээ болон жижиг, дунд үйлдвэрлэгчдэд олгосон зээлийн өсөлт гол нөлөө үзүүлж байна. 2021 онд Голомт банк чанаргүй активыг бууруулахад анхаарал хандуулсны үр дүнд чанаргүй зээлийн харьцаа 1.2 нэгж хувиар, өмчлөх бусад хөрөнгийн дүн 49 хувиар буурчээ.


Өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 27 тэрбум төгрөгөөр өсөж, 659 тэрбум төгрөгт хүрснээр Монголбанкны шаардлагыг бүрэн ханган ажиллаж байна.

Зураг 3.11. Цэвэр зээл (тэрбум төгрөг)



Зураг 3.12. Өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)






Өөрийн хөрөнгө нь тогтмол өсөлттэй байгаа нь цаашид өсөх боломжтойг харуулж байна.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээлийн төвлөрөл, төлбөрийн чадвар, гадаад валютын эрсдэлтэй холбоотой Монголбанкны бүх шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллалаа.

Зураг 3.13. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар



Дараах хүснэгтэд сүүлийн 5 жилийн санхүүгийн үзүүлэлтэд санхүүгийн байдлын шинжилгээ хийв.

Хүснэгт 3.4 Голомт банкны 5 жилийн санхүүгийн үр дүн(сая төгрөгөөр)

| Үзүүлэлтүүд (сая төгрөг) | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 |
|--------------------------|------|------|------|------|------|
|--------------------------|------|------|------|------|------|

|   |        |        |       |       |        |
|---|--------|--------|-------|-------|--------|
| <b>Нийт актив</b>                       | 5,205  | 6,081  | 6,643 | 7,278 | 7,994  |
| Өсөлтийн хувь                           | 11.7%  | 16.8%  | 9.2%  | 9.6%  | 9.8%   |
| Харилцах, хадгаламж                     | 3,454  | 4,403  | 4,901 | 5,286 | 5,464  |
| Өсөлтийн хувь                           | 23.2%  | 27.5%  | 11.3% | 7.9%  | 3.4%   |
| Зээлсэн эх үүсвэр                       | 758    | 716    | 916   | 1,202 | 1,509  |
| Өсөлтийн хувь                           | -36.6% | -5.5%  | 28.0% | 31.2% | 25.6%  |
| Цэвэр зээл                              | 2,318  | 3,184  | 3,307 | 3,031 | 3,339  |
| Өсөлтийн хувь                           | 13.9%  | 37.3%  | 3.9%  | -8.3% | 10.2%  |
| Нийт өөрийн хөрөнгө                     | 489    | 606    | 635   | 632   | 659    |
| Өсөлтийн хувь                           | 7.7%   | 23.9%  | 4.8%  | -0.5% | 4.3%   |
| Нийт зээл-хорогдуулсан өртгөөр          | 2,414  | 3,357  | 3,428 | 3,191 | 3,500  |
| Зээлийн сан                             | 96     | 173    | 121   | 160   | 161    |
| NPL                                     | 113    | 176    | 141   | 203   | 183    |
| NPL (%)                                 | 4.7%   | 5.2%   | 4.1%  | 6.4%  | 5.2%   |
| NPL coverage (%)                        | 84.4%  | 98.4%  | 85.9% | 79.0% | 88.2%  |
| Цэвэр ӨБҮХХ, түүнтэй адилтгах актив     | 157    | 159    | 251   | 277   | 198    |
| Өсөлтийн хувь                           | 38.4%  | 1.2%   | 57.8% | 10.5% | -28.4% |
| Хүүгийн орлого                          | 409    | 494    | 578   | 570   | 555    |
| Хүүгийн зардал                          | (287)  | (323)  | (366) | (366) | (273)  |
| Цэвэр хүүгийн орлого                    | 122    | 171    | 212   | 204   | 282    |
| Өсөлтийн хувь                           | 42.7%  | 39.9%  | 24.1% | -3.6% | 38.0%  |
| Цэвэр хүүгийн бус орлого                | 8      | 136    | 81    | 83    | 49     |
| Свопын нөлөө                            | (65)   | 93     | 15    | 15    | (22)   |
| <b>Цэвэр хүүгийн бус орлого-свопгүй</b> | 73     | 42     | 66    | 68    | 70     |
| <b>Үйл ажиллагааны орлого</b>           | 130    | 306    | 293   | 287   | 331    |
| <b>Үйл ажиллагааны орлого-свопгүй</b>   | 195    | 213    | 278   | 272   | 352    |
| Өсөлтийн хувь-свопгүй                   | 54.7%  | 9.0%   | 30.5% | -2.0% | 29.4%  |
| Үйл ажиллагааны зардал                  | (86)   | (110)  | (122) | (121) | (117)  |
| Үйл ажиллагааны ашиг                    | 44     | 196    | 171   | 166   | 235    |
| <b>Үйл ажиллагааны ашиг-свопгүй</b>     | 110    | 103    | 156   | 151   | 215    |
| Өсөлтийн хувь-свопгүй                   | 123.8% | -6.4%  | 51.6% | -2.9% | 42.2%  |
| Сан, үнэлгээний зардал                  | 36     | 94     | 146   | 143   | 141    |
| Зээл                                    | 33     | 84     | 140   | 102   | 52     |
| ӨБҮХХ                                   | 3      | 8      | 5     | 40    | 90     |
| Бусад                                   | 0      | 2      | 2     | 1     | (1)    |
| Зээл                                    | 91%    | 89%    | 96%   | 71%   | 37%    |
| ӨБҮХХ                                   | 8%     | 8%     | 3%    | 28%   | 64%    |
| Бусад                                   | 0%     | 3%     | 1%    | 1%    | -1%    |
| Сангийн зардал-өсөлтийн хувь            | -37.9% | 158.2% | 55.3% | -1.8% | -1.8%  |
| Цэвэр ашиг                              | (5.2)  | 53.5   | 16.3  | 10.4  | 25.9   |
| ROAA                                    | N/A    | 1.0%   | 0.3%  | 0.2%  | 0.3%   |
| ROAE                                    | N/A    | 16.1%  | 3.3%  | 2.5%  | 5.1%   |
| Цэвэр хүүгийн маржин                    | 3.6%   | 4.4%   | 4.2%  | 4.0%  | 4.6%   |

|  |       |       |       |       |       |
|--|-------|-------|-------|-------|-------|
| CIR  | 65.8% | 35.9% | 41.7% | 42.2% | 41.5% |
| Зардал, орлогын харьцаа-свопгүй                | 44%   | 52%   | 44%   | 44%   | 39%   |
| Өөрийн хөрөнгийн хүрэлцээ > 12%<br>(2019:<14%) | 14.4% | 15.4% | 14.9% | 15.5% | 15.4% |
| Tier1 >9% /нөөц +1%/                           | 9.5%  | 12.5% | 10.1% | 15.1% | 15.0% |
| Монголбанкны шаардлага                         | 9.0%  | 9.0%  | 9.0%  | 10.0% | 10.0% |
| Нийт гадаад валют <+/-30% (2019:<+/-<br>40%)   | 15.3% | 5.5%  | 12.7% | 23.2% | 12.6% |
| Нэгж гадаад валют < +/-15%                     | 11.1% | 2.0%  | 0.8%  | 11.7% | 10.0% |
| Том зээлдэгч < 20%                             | 16.8% | 15.3% | 15.0% | 16.2% | 13.3% |
| Холбоотой этгээд < 5%                          | 4.2%  | 3.8%  | 4.4%  | 4.0%  | 1.3%  |
| Холбоотой этгээд-Нийт < 20%                    | 17.9% | 16.6% | 15.0% | 13.2% | 3.6%  |
| ТТГЧ харьцаа > 25%                             | 44.5% | 36.6% | 32.7% | 40.0% | 41.1% |
| Монголбанкны шаардлага                         | 25.0% | 25.0% | 25.0% | 25.0% | 25.0% |

## ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар Голомт банкны орлогын өсөлт, үйл ажиллагааны зардлыг бууруулах замаар дижитал шилжилтийн нөлөөллийг хэрхэн зохицуулж байгааг судалсан. 2017 оноос хойш орлогын өсөлтөд SocialPay нөлөө эерэг ба үйл ажиллагааны зардлыг бууруулж байгааг жилийн тайлангаас харж болно. Мөн Ковид-19 цар тахлын үеийн нөхцөл байдлыг судаллаа. Энэхүү хүнд цаг үе нь банкууд үйл ажиллагааны зардлаа бууруулж, орлогоо нэмэгдүүлэхэд тусалсан. Санхүүгийн шинжилгээний үр дүнгээс дүгнэвэл сонгож авсан банк дижитал шилжилт хийснээр жилд дунджаар 47.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж зээлийн олголтын процесс илүү хурдтай, илүү шуурхай шийдвэрлэх боломжийг олгожээ. 2021 онд зээлийн үлдэгдлийн хэмжээ 82.9 тэрбум төгрөгөөр өссөн. Зээл олголт, зээлийн үлдэгдлийн хэмжээ 3.2 дахин өссөн боловч чанаргүй зээлийн нийт зээлийн дүнд эзлэх хувь хэмжээ шилжилтийн өмнөх үетэй ижил түвшинд байсан, цар тахлын үеийн нөлөөлөл бага байгаа зэргээс харахад дижитал шилжилт хийж, финтекээр зээлийн шийдвэр гаргаж ажиллах нь уламжлалт байдлаар зээл олголтыг шийдэх үеэс зээлийн эрсдэлийн хувьд өсөөгүй байгаа нь сайн үзүүлэлт гэж үзэж байна. Голомт банкны нийт ашигт хамаарах түүврийг сонгон авч, түүврүүд дээр шинжлэн үнэлгээ хийж, түүний үр дүнг тайлбарласан. Үнэлгээний үр дүнд ихэнх тайлбарлагч хувьсагч түүвэрт хамааралтай гарч байсан.

Судлаачийн хувьд шинжилгээний хэсэгтээ банкны гол үзүүлэлтүүдийн үндсэн үйл ажиллагаануудыг дижитал шилжилт нэвтрүүлэхээс өмнөх үе, Ковид-19 цар тахлын үе,

дигитал шилжилт ашиглан хэрэглэгчдэд хүргэж байгаа үе гэсэн байдлаар сүүлийн 5 жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдэд шинжилгээ хийн, харьцуулан дүгнэв.

Голомт банкны ашигт ажллагаанд судалгаа хийж үзэхэд ашигт ажиллагааны түвшин харилцан адилгүй байна. Мэдээж хэрэг энэ нь олон хүчин зүйлтэй хамааралтай юм. Эцэст нь дүгнэн хэлэхэд банкны ашгийг нэмэгдүүлэх дараах боломжуудыг тодорхойлж байна. Үүнд:

- ✓ Банкны дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох замаар үйл ажиллагааны эрсдлийг бууруулах;
- ✓ Актив, пассивын хосолсон удирдлагыг өнөө үед тохируулан хэрэгжүүлэх;
- ✓ Банкны маркетингийн үйл ажиллагааг зөв удирдан явуулах;
- ✓ Эрсдлийг зөв удирдан жолоодох;
- ✓ Үйлчүүлэгчдийн сэтгэл ханамжийг өндөр байлгах;
- ✓ Үйл ажиллагааны зардал хэмнэх;
- ✓ Хүүгийн түвшинг зах зээлд тохируулан өөрчилж байх;
- ✓ Шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх.

## ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ АШИГТ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛӨХ НЬ/АРИЛЖААНЫ БАНКНЫ ЖИШЭЭН ДЭЭР/

### НОМ ЗҮЙ

Судлаачийн эмхэтгэлээс. (огноо байхгүй). Судлаачийн эмхэтгэлээс.

Хөдөлгөөнт банкны тайлан. (2022). *Хөдөлгөөнт банкны тайлан*. Улаанбаатар: mongolbank.

Elizabeth Judd. (2017). *Timeline: 180 years of banking technology*.  
<https://independentbanker.org/2017/10/timeline-180-years-of-banking-technology/>:  
<https://independentbanker.org/2017/10/timeline-180-years-of-banking-technology/>-ээс  
Гаргасан

emongolia. (2020 оны 12 14). *montsame*. montsame.com:  
<https://montsame.mn/mn/read/246236>-ээс Гаргасан

golomtbank. (2022). *Банкны бүх үйлчилгээг цахимаар авах боломж*.  
<https://golomtbank.com/retail/digital-bank/internet-bank>:  
<https://golomtbank.com/retail/digital-bank/internet-bank>-ээс Гаргасан

<https://mn.wikipedia.org/wiki/Банк>. (огноо байхгүй). <https://mn.wikipedia.org/wiki/Банк>.  
<https://mn.wikipedia.org/wiki/Банк>:  
<https://mn.wikipedia.org/wiki/%D0%91%D0%B0%D0%BD%D0%BA>-ээс Гаргасан

ikon.mn. (2021). *Хурдацтай хөгжилд нийцсэн хууль дүрэм, эрх зүйн орчин хэрэгтэй байна*. Улаанбаатар: ikon.mn.

ikon.mn. (2022). *Интернэт хэрэглэгчдийн тоо*. ikon.mn.

itoim.mn. (2020). *Дижитал шилжилт*. itoim.mn: <http://itoim.mn/article/Z69kW/24336>-ээс  
Гаргасан

Itpartner.mn. (2020). Аж үйлдвэрийн 4-р хувьсгал. Улаанбаатар.

khanbank.com. (2021). *khanbank*. khanbank.com: khanbank.com-ээс Гаргасан

lemonpress.mn. (2022). *lemonpress*. lemonpress: lemonpress.mn-ээс Гаргасан

Lihua Zuo, J. S. (2021). The Digitalization Transformation of Commercial Banks and Its impact on sustainable efficiency improvements through investment in Science and Technology. 12.

mongolbank. (2022). *mongolbank*. Банкуудын өрсөлдөөний тойм:  
[https://ecrc.mn/media/ecrc/content/Bank%20research/2021/Bank-report-2021Q4\\_mon.pdf](https://ecrc.mn/media/ecrc/content/Bank%20research/2021/Bank-report-2021Q4_mon.pdf)-ээс Гаргасан

PwC, s. (2018). *Global Digital Operations*.

Stefanini. (2022). <https://stefanini.com/en/solutions/digital>.-ээс Гаргасан

TDBM.mn. (огноо байхгүй). *TDBM*. TDBM.mn.-ээс Гаргасан

unread. (2020). *unread.today*. <https://unread.today/c/insight-digitalbanking>:  
<https://unread.today/c/insight-digitalbanking>-ээс Гаргасан

Yonghwan Kim. (2016). *Digital Media Use and Social Engagement: How Social Media and Smartphone Use Influence Social Activities of College Students*. liebertpub.com.-ээс  
Гаргасан

- Анхзүсэм, З. (2017). *Арилжааны банкны цахим үйлчилгээнд ТТҮҮБ-н оролцоог нэмэгдүүлэх нь*. Улаанбаатар: Санхүү Эдийн Засгийн Их Сургууль.
- Билгүүнгэрэл, Г. (2017). *Цар тахлын үеийн цахим банкны үйлчилгээний чанарыг сайжруулах нь*. Улаанбаатар: Санхүү Эдийн Засгийн Их Сургууль.
- блокчейн*. (огноо байхгүй). <https://mn.wikipedia.org/wiki/блокчейн>:  
[https://mn.wikipedia.org/wiki/блокчейн-ээс Гаргасан](https://mn.wikipedia.org/wiki/блокчейн-ээс_Гаргасан)
- Бэлгүтэй, З. (2020). *Дижитал шилжилтэд үндэслэн монголын арилжааны банкнуудын бизнес загварыг сайжруулах нь*. Улаанбаатар: Санхүү Эдийн Засгийн Их Сургууль.
- Гангармаа. (2014 оны 2 14). *Интернет худалдаа ба интернет банк*.  
<https://www.slideshare.net/batnasanb/ss-31198638>:  
[https://www.slideshare.net/batnasanb/ss-31198638-ээс Гаргасан](https://www.slideshare.net/batnasanb/ss-31198638-ээс_Гаргасан)
- Голомт банк жилийн тайлан. (огноо байхгүй). *Голомт банк жилийн тайлан*.  
Улаанбаатар: [golomtbank.com](http://golomtbank.com).
- Нанософт. (2018). *facebook.com*.
- тайлан, Г. б. (2018). *Голомт банкны санхүүгийн тайлан*. Голомт банк.
- Ундрал, З. (2020). *Арилжааны банкуудын дижитал шилжилтийн бэлэн байдлыг үнэлэх нь*. Улаанбаатар: Санхүү Эдийн Засгийн Их Сургууль.